# БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 27 өдөр Дугаар А/286 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1434 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн 1, 2 дугаар хороонд Тохижилт, ногоон байгууламжийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Б.Гэрэлмаа | Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын захирал |
| Гишүүд: | Ё.Гэрэлцэцэг | Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | Ч.Батхуяг | Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын захирал |
| | П.Бор | 2 дугаар хорооны иргэн |
| Нарийн бичиг | Д.Амгалан | Худалдан авах ажиллагааны албаны Ахлах мэргэжилтэн |

2.Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Б.Гэрэлмаа)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2023 он ажил\захирамж